МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 06 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудас
	Хуралдааны товч тэмдэглэл:	
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	19
	.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	3-19 19-19

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 06 дугаар сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дараалыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 23 минутад Төрийн ордны "Их эзэн Чингис хаан" танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьшаа, С.Бямбацогт, Л.Энх-Амгалан.

Нэг.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх****/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ш.Ариунжаргал, Ц.Баянмөнх, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Доржханд, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Баярсайхан, Б.Баттөмөр, Х.Баделхан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Баттөмөр, Б.Баярсайхан, Б.Бат-Эрдэнэ, Ж.Мөнхбат нар үг хэлэв.

Б.Бат-Эрдэнэ: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 0
Бүгд: 6
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 06 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2022 оны 6 сарын 8-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог нэрээр нь хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүн, хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирээгүй гишүүн, хуралдаан тасалсан гишүүн гэсэн дараалаар танилцуулна. Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Б.Бат-Эрдэнэ Хэнтийн 18 дугаар тойрог ирсэн, Адьшаа гишүүн Ховд 16 дугаар тойрог орон нутагт томилолтой яваа, Х.Баделхан гишүүн Баян-Өлгий 2 дугаар тойрог хүрэлцэн ирсэн, Б.Баттөмөр гишүүн Дархан-Уул аймаг 19 дүгээр тойрог хүрэлцэн ирсэн, Б.Баярсайхан гишүүн Завхан аймгийн 9 дүгээр тойрог хүрэлцэн ирсэн, Бейсен гишүүн Баян-Өлгий аймаг 2 дугаар тойрог хүрэлцэн ирсэн, С.Бямбацогт гишүүн Ховд аймгийн 16 дугаар тойрог гадаад томилолттой, Ж.Мөнхбат гишүүн Архангай аймгийн 1 дүгээр тойрог ирсэн, Л.Энх-Амгалан гишүүн Хөвсгөл аймаг 17 дугаар тойрог гадаад томилолтой, Б.Энхбаяр гишүүн 22 дугаар тойрог Баянзүрх дүүрэг мөн томилолттой байна. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хуралдаанд Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал хоёр асуудал хэлэлцэнэ.

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат нарын 4 гишүүний 2022 оны 5 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

2.Байнгын хорооны тогтоолын төсөл, 6 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай ийм хоёр асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хийе. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгыг төсөл санаачлагч Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат танилцуулна. Таныг танилцуулга хийхийг урьж байна. Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгөөрэй.

Ж.Мөнхбат: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан болон миний бие, ийм бүрэлдэхүүнтэй 2022 оны 5 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байгаа. Улсын

Их Хурлын нэр бүхий гишүүдээс санаачлан төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн энэ төслийг нэлээн судалгаа тооцоонд үндэслэж боловсруулж өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа нь эрх мэдлийн харилцан хяналттай, тогтвортой, хариуцлагатай эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн гэдгийг бид бүхэн мэдэж байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн энэ агуулга, үзэл санаанд нийцүүлж, эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж, хэрэгжүүлж байгаа энэ цаг хугацаанд төрийн албаны засаглах чадамжийг сайжруулах, сахилга хариуцлагыг нь дээшлүүлэх, ард түмэндээ үйлчилдэг ёс зүйтэй, хариуцлагатай, мэргэшсэн, ур чадвартай төрийн албыг төлөвшүүлэх, төр, ард түмний итгэлцлийг улам бататгах энэ чиглэлээр шаардлагатай хууль тогтоомжийг батлан гаргах шаардлага зайлшгүйгээр өнөөдөр бол үүсэн бий болоод байгаа нөхцөл байдлын хувьд.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, ард иргэдийнхээ санал бодлыг сонсоход санал асуулга явуулах Улсын Их Хурлын шийдвэр гарч 2017 оны 4 сарын 27-ны өдөр зөвлөлдөх зөвлөлийг байгуулж, зөвлөлдөх санал асуулгыг Монгол Улсад анх удаагаа зохион байгуулсан. Энэ зөвлөлдөөн санал асуулгад оролцогчдын 94.5 хувь нь төрийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга механизмыг үндсэн хуулиар бий болгоё, 89.4 хувь нь бол төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлэхийг, 87.9 хувь нь төрийн жинхэнэ албыг мэргэшсэн, мэдлэг чадварт суурилсан, ур чадварт суурилсан улс төрөөс ангид байхыг дэмжиж, энэ чиглэлээр эрх зүйн хамгаалалтыг бий болгох асуудлыг Үндсэн хуулийг өөрчлөх энэ хүрээнд хөндөх нь зүйтэй гэсэн ийм саналыг бас өгч байсан.

Энэ судалгаануудаас харах юм бол ер нь төрийн албыг хариуцлагатай, ур чадвартай, хүнд сурталгүй, улс төрөөс ангид байлгах, ёс зүйтэй, сахилга хариуцлагатай байлгах ийм асуудлыг бол энэ санал асуулгад оролцсон бүгдээрээ 80-аас дээш, 90-ээс дээш хувийн саналаар санал өгсөн байдаг юм. Монгол Улсын Их Хурлаас бол Төрийн албаны тухай хуулийг 1995 онд баталж, хоёр удаа буюу 2002 онд, 2017 онд тус тус шинэчлэн найруулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох, сахилга хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг бий болгох энэ нөхцөлийг бүрдүүлсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар хууль журам, дүрэм цөөнгүй байгаа боловч төрийн албаны бүх түвшинд энэ ёс зүй, хариуцлагын арга хэмжээний үр нөлөө багатай байгаа зохицуулалт нь сул хэвээр байгаа гэж үзэж байна.

Ёс зүйн дүрэм үйлчилж байгаа хэдий ч ёс зүйн зөрчил, маргааныг шийдвэрлэх, мөрдүүлэх, хэвшүүлэх энэ тогтолцоо бас бүрэн, нийгмийн хүлээлтийн түвшинд ажиллаж чадахгүй байна. Тийм учраас энийг сайжруулах ёстой гэсэн ийм зүйлийг иргэдээс ярьж байгаа. Иймд төрийн албаны энэ ёс зүйн нийтлэг асуудлыг нэгдмэл байдлаар нь зохицуулах энэ ерөнхий хуулийг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд санаачлаад энийг батлуулъя гэж ингэж санал гаргаж оруулж ирж байгаа. Энэ хуулийг батлан гаргах, түүнд бүх төрийн албан хаагчдын сахин мөрдөх нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тогтоож, энэ тогтсон хэм хэмжээг зөрчсөн нөхцөлд бол хүлээлгэх хариуцлагын төрөл, түүнчлэн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг тогтоох зорилгоор төрийн албан хаагчийн энэ ёс зүйн тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл 6 бүлэг 19 зүйлтэй байгаа. Энэ хууль нь бол төрийн албаны харилцаанд төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааг зохицуулах анхдагч хууль болохын хувьд төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааны нийтлэг асуудлыг тусгана гэж заасан. Нэгдүгээрт бол, ёс зүйн хэмжээ, зөрчил, хариуцлагын талаарх ёс зүйн харилцааны суурь ойлголтыг өгч байгаа.

Хоёрдугаарт, энэ хууль төрийн, улс төрийн захиргааны тусгай, үйлчилгээний албан хаагчид нэгэн адил үйлчлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тогтоохоор зааж байгаа бол албаны чиг үүргийн онцлогтой уялдуулсан тусгай зохицуулалтыг бол бусад хууль тогтоомжоор тогтоож болохыг бас зааж өгсөн.

Гуравдугаарт бол, энэ төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг хариуцах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн байдалд хяналт тавих бүтэц, зохион байгуулалтыг бол тодорхойлон заасан байгаа.

Үүнд бол төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан, албан хаагчдынхаа ёс зүйг сахин мөрдүүлэх орчин нөхцөлийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах, ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллуулах, зөрчил үйлдсэн албан хаагчдад хариуцлага тооцох зэрэг үндсэн чиг үүргүүд бол энд чиг үүргүүдтэй ажиллана. Харин улсын хэмжээнд ёс зүйн асуудлыг нэгтгэн зохицуулах, нэгдсэн арга зүйгээр хангах, хуулиар харьяалуулсан гомдлыг хянан шийдвэрлэх үүрэгтэй Ёс зүйн хороог Төрийн албаны зэргийн зөвлөлийн дэргэд байгуулж ажиллуулахаар болж байгаа энэ хуулийн зохицуулалтаар.

Дөрөвдүгээрт бол, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол хүлээж авах, хянан шалгах, дүгнэлт гаргах, шийдвэрээ томилох, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх зэрэг гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг бол ерөнхийд нь бол хуульчилж байгаа.

Тавдугаарт, төрийн албан хаагчид ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг төрлийг нь тогтоож ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл журмыг заасан. Төрийн албан хаагчийн ёс зүйн алдаа гаргасан бол сануулах, уучлал гуйхыг үүрэг болгох ажлаас салахыг сануулах, ажлаас халах гэсэн ийм шат дараатай хариуцлага тооцох механизм бий болно. Албан тушаалтан өөрөө хариуцлага хүлээх соёлыг төлөвшүүлэх зорилгоор уучлал гуйдаг, албан тушаалаасаа сайн дурааараа огцорч, ёс зүйн хариуцлагаа хүлээдэг ийм боломжийг бас энэ хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төслийг баталснаар улсын хэмжээнд удирдан зохицуулах нэгдсэн зохицуулалттай болж, төрийн болон орон нутгийн байгууллагын бүх шатанд төрийн албаны ёс зүй, соёлыг төлөвшүүлэхэд ахиц гарах, улмаар иргэд ёс зүйтэй, чанартай, хариуцлагатай, ийм төрийн үйлчилгээ авах боломж бүрдэнэ гэж хууль санаачлагчид үзэж, энэ хуулийн төслийг боловсруулж та бүхэнд хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсэж, өнөөдөр хэлэлцүүлж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Их баярлалаа. Тэгэхээр та бид бүгдээрээ мэдэж байгаа, 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Их Хурал ёс зүйн асуудал, төрийн албан хаагчдын ёс зүйн бодлого, ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой энэ асуудалд онцгой анхаарал тавьсан. Олон улсын практикт ийм байгаа юм. Хөгжингүй улс орнууд, парламент ёс төлөвлөсөн хууль, эрх зүйт ийм төр төлөвшсөн, ардчилсан

улс орнуудад энэ төрийн албаны төрийн албан хаагчдын ёс зүйн сахилга хариуцлагыг нэн тэргүүнд авч үзэж байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дэргэд үйл ажиллагаа явуулж байсан ёс зүйн дэд хороог өргөтгөж Улсын Их Хурлын тухай хууль баталж, хуульдаа оруулж, Байнгын хорооны эрх асуудлын хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын бодлого, төрийн албаны бүх шатны ёс зүйн хороо, хороо, зөвлөлийн асуудлуудыг хамаарахаар ингэж хуульчилж өгсөн. Тийм учраас манай Байнгын хороо бол төрийн албаны шинэтгэл, төрийн албанд байх ёс зүй, сахилга хариуцлагын чиглэлээр ямар хувь нэмэр оруулах вэ гэдэг асуулт бид нарын анхаарлын төвд байгаа. Тийм учраас өнгө өнгөрсөн хугацаанд нэлээн тодорхой ажлуудыг та бид хамтдаа хийж хэрэгжүүлж ирсэн. Энэ Улсын Их Хурлын тухай хуулиар Улсын Их Хурлаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо байгуулагдмагц 2020 оны 9 дүгээр сард дөрвөн өдөр дараалан бид Төрийн албаны зөвлөлтэй хамтарч төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Энэ зөвлөгөөнд Улсын Их Хурлаас томилогддог байгууллага, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн удирдлага бол аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дэргэдэх ёс зүйн хороо, зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүд зэрэг нийт 5000 орчим хүмүүсийг биечлэн болон цахимаар КОВИД-ын хүнд нөхцөл байдалтай ч гэсэн зохион байгуулсан. Энэ зөвлөгөөнөөр төрийн байгууллагуудын ёс зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ёс зүйн зөрчлийг шалган тогтоох, хариуцлага тооцох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох, харилцаа хандлагыг шинэчлэх зэрэг ийм тулгамдсан асуудлуудаар нэлээн сайн зөвлөгөөнүүдийг бид хийсэн.

Түүнчлэн 2022 оны 12 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн цахилгаан хариуцлагын бодлого, эрх зүйн орчин, онол, практик арга зүйн асуудлыг төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулах сургалт хэлэлцүүлгийг Сэлэнгэ, Хэнтий зэрэг ийм аймгуудад зохион байгуулсан. Мөн энэ үеэрээ одоо энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлдөө санал авч, хэлэлцүүлэг хийж ингэж ажилласан.

Ер нь Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн мэдээллээс үзэхэд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажилласнаар сүүлийн жил гаруй хугацаанд төрийн байгууллагуудын дэргэд байгуулагдсан ёс зүйн зөвлөлүүдийн үйл ажиллагаа үндсэндээ жигдэрч ёс зүйн зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж байгаа нь Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажилд ахиц гарсныг харуулж байгаа. Байнгын хорооны хурлаар Төрийн албаны зөвлөлийн мэдээлэл, тайланг бид нар хэлэлцсэн, та бүхэн мэдэж байгаа. Мөн манай Байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо инновац цахим бодлого, цахим үндэстэн болох энэ хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны зөвлөлд бид нар биечлэн ажилласан. Энэ бүх үйл ажиллагаа бол төрийн албаны шинэтгэл үзүүлэх парламентын дэмжлэг болж байгаа гэж ингэж бид үзэж байгаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо санаачилга гаргаад Улсын Их Хурлын даргын ивээл дор Төрийн албаны үндэсний хэмжээний форум, чуулга уулзалт хийе гэсэн санал, санаачилгыг гаргасан. Даргын

дэргэдэх зөвлөл дэмжээд холбогдох Байнгын хороодын дарга нар оролцоод, чуулга уулзалтыг Төрийн албаны шинэтгэл, ололт, сорилт шийдэл гэсэн ийм уриа зохион байгуулахаар бид төлөвлөж бас ажиллаж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй. Энэ төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг боловсруулах чиглэлээр 2021 оны 4 сарын 2-нд Улсын Их Хурлын даргын 25 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, бид ажилласан. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Баатарбилэг гишүүн, гишүүдэд Батжаргал гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүн, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дарга Тогтохсүрэн гишүүн, С.Чинзориг Улсын Их Хурлын гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гараад бид нар ажилласан.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад Төрийн албан хаагчийн ёс зүй тухай хуулийн төсөл, түүнд холбогдох материал, албан хэрэгцээнд зориулж зориулсан Тамгын газартай хамтраад ийм материал бид нар бэлтгэсэн хэлэлцүүлгүүдийг хийсэн. Түүнчлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг манай ажлын хэсэг ахлагч энэ хууль журам, хууль боловсруулах шаардлагын хүрээнд хэлэлцүүлэг хийж, энэ материалуудыг бид нар бэлтгэж ингэж ажилласан гэдгийг Байнгын хорооныхоо нийт гишүүдэд би товч танилцуулж байна.

Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуудалтай гишүүд байвал нэрээ өгнө үү. Баделхан гишүүнээр асуулт асуух гишүүдийн нэрийг тасаллаа. Бейсен гишүүн асуултаа асууя, микрофоныг нээж өгөөрэй.

Б.Бейсен: Та бүгдэд өглөөний мэнд хүргэе. Энэ Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн төсөл болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Гэхдээ бас асуудал байна. Төрийн алба бол аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалгүйгээр иргэдэд үйлчлэх ёстой. Гэтэл төрийн алба улс төржих болсон, сүүлийн үед. Ялангуяа орон нутагт ерөөсөө намын гишүүд ажиллаж байгаа мэт ингээд ажилладаг, тэр ажил цалгарддаг асуудлууд байж байна. Зарим нь төрийн ёс зүйг алдаж байгаа асуудлууд ч байж байна. Одоо 2 жил өнгөрчихсөн байхад Толбо сумын Засаг дарга одоо хүртэл томилогдоогүй асуудал байж байна. Тэгээд төрийн ажил цалгарч байна. Энэ асуудал дээр энэ хуулийн төсөл дээр нарийвчлан оруулж өгөөд, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлах тал дээр Төрийн албаны зөвлөл нь анхаарч ажиллах нь чухал байх гэж бодож байна. Иргэдийн эрх чөлөөг хангах, иргэдийг хүндлэх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх нь чухал байна.

Ёс зүйн зөрчил гаргахад хүлээлгэдэг хариуцлагыг тодорхой байвал төрийн албан хаагчид алдаа дутагдал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллана шүү дээ. Тиймээс энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Саналаа бас тусдаа хэлье. Энэ хуулийн төсөлтэй холбоотой санал ярих үед ярья.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Бейсен гишүүний асуултад төсөл санаачлагч, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Жамъянгийн Мөнхбат гишүүнд микрофон нээж өгье.

Ж.Мөнхбат: Бейсен гишүүн маань энэ төрийн алба ялгаварлан гадуурхахгүй үйлчлэх ёстой, төрийн албаны ажил цалгарддаггүй байх ёстой, төрийн ажил, улс төрждөггүй, намчирхдаггүй байх ёстой гэдэг бас үндсэн агуулгыг ярьж байх шиг байна.

Энэ бол Төрийн албаны тухай хуулийн зүйл заалтуудаар бол маш тодорхой зааж өгсөн зохицуулалтууд уг нь байж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бид бүхний энэ шинэчлэн найруулсан 2017 онд баталж, хэрэгжиж байгаа Төрийн албаны тухай хуулиар бол Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж иргэдэд үйлчлэх ёстой, төрийг төлөөлж ажиллаж байгаа төрийн албаныхан бол улс төржихгүй, намжихгүй байх ёстой. Ямар нэгэн иргэнийг аливаа нэгэн асуудлаар ялгаварлан гадуурхахгүй байх ёстой. Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуульд заагдсан хүний үндсэн эрх гэж бий. Хуульчилсан эрхүүд бий. Тийм учраас энэ ялгаварлан гадуурхахгүй байх ёстой. Энэ бүх зүйлүүдийг бол Төрийн албаны тухай хуульд бол зааж өгсөн.

Толбо сумын Засаг даргыг одоог хүртэл томилогдоогүй төрийн ажил цалгардаж байна гэж байна. Энэ бол бас Төрийн албаны тухай хуулиар бид нар 2017 онд зохицуулалтыг нь хийгээд хуульчлаад өгчихсөн байж байгаа. Ямар нөхцөл байдал, ямар үндэслэлээр энэ Засаг даргыг өнөөдөр хүртэл томилогдоогүй байгаа вэ гэдэг энэ асуудлыг бол дээд шатны засгийн бүтэц өөрөөр хэлэх юм бол дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, энэ бүхэнд Төрийн албаны зөвлөлд төрийн албаны хууль зөрчигдөж байна гэх юм бол ингээд тавих боломж байгаа юм. Өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа энэ хууль бол төрийн албан хаагчийн ёс зүйн асуудалтай холбоотой, сахилга хариуцлагатай холбоотой. Өөрөөр хэлэх юм бол тэр хүн ёс зүйн алдаа гаргасан бол, сахилгын хариу алдаа гаргасан бол хариуцлага яаж хүлээлгэх вэ гэдэг энэ зүйлийг бид нар хуульчилж өгч байгаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хүлээх хариуцлагыг тодорхой болгочих юм бол нэлээн юм цэгцэрнэ гэж Бейсен гишүүн хэлж байна. Энэнтэй санал нэг байгаа. Манай хуульд бол дөрвөн янзын ийм хариуцлагын асуу механизм орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол тэр хүн ёс зүйн алдаа гаргасан бол уучлал гуйх, тэр хүнд сануулах, сайн дурааараа ажлаасаа халагдах, ажлаас нь халах гээд гэх мэтчилэнгийн ийм шат дараатай хариуцлагын механизмыг бол энд хуулийн төсөлд бол хийж өгсөн.

Ер нь бол тантай бас нэг санал нэг байгаа зүйл нь бол төрийн алба бол хүнд сурталгүй, ялгаварлан гадуурхахгүй үйлчлэх ёстой гэдэг, иргэдэд үйлчлэхдээ. Дээрээс нь хуулийг ягштал биелүүлэх ёстой гэдэг энэ зүйлийг бол, Төрийн сүлд нь тангараг өргөж байгаа шүү дээ, төрийн албан хаагчид бол. Тэгэхээр энэ асуудал дээр бол санал нэг байна. Таны асуусан асуулт бол манай хуульд бол ёс зүйн сахилгын хариуцлага алдсан бол зохицуулалтууд саяын байдлаар тусгагдаж байгаа гэдгийг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Бейсен гишүүнд тодруулга 1 минут өгье.

Б.Бейсен: Төрийн алба бол ер нь чадварлаг улс төрийн мэдлэг өндөр байх ёстой. Энэ улс төржилтөөс болоод чадварлаг мэдлэгтэй боловсон гишүүд төрийн албанд орж чадахгүй байна. Тийм учраас бас энэ төрийн ажил цалгардах асуудал гарч байна л даа. Энэ тал дээр бас санаа зовж байгааг хэлэх гэсэн юм.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Үг хэллээ. Б.Баярсайхан гишүүнд микрофон өгье. Асуултаа асууя.

Б.Баярсайхан: Миний бие энэ хуулийг бас өргөн барилцаж байгаа гишүүний хувьд энэ хууль заавал батлагдах ёстой, энэ бол чухал хууль гэдгийг нэгдүгээрт хэлмээр байна. Хоёрдугаарт, энэ хууль хэлэлцэгдэж байх явцад үргэлж сайжирч байх

ёстой болохоор өнөөдөр бас энэ Ёс зүйн байнгын хороон дээр хоёр зүйлийг хэлмээр байна. Бид нарын хийсэн энэ хуулийн төсөл дээр 8.1.3-ын “а” дээр өргөсөн тангарагтаа үнэнч байж гээд төрийн албан хаагчдыг тангараг өргөдөг гэсэн ойлголтоор оруулсан. Гэхдээ яг амьдрал дээр төрийн захиргааны жинхэнэ албан хаагч, эмч, хуульч, хууль хүчний байгууллагынхан, сайд, гишүүд өнөөдөр тангараг өргөж байгаа. Бусад төрийн албан хаагчид тангараг өргөхгүй байгаа юм. Тэгэхээр ер нь бүх төрийн албан хаагчид тангараг өргөдөг болмоор байгаа юм. Тэгэхгүй бол өргөсөн тангарагтаа үнэнч байж гээд ингэхээр тангараг өргөөгүй төрийн алба хаагчдад энэ зүйл, заалт нөлөөлдөггүй ийм асуудал байна.

Хоёрдугаарт, ёс зүйн хороо, ёс зүйн зөвлөлийн ажлыг эрх үүргийг нь бүр улам сайжруулж, хариуцлагыг нь бас өндөржүүлмээр байгаа юм. Жишээлбэл өнөөдөр төрийн албан хаагчдын, төрийн албаны нэр хүнд тийм хангалттай сайн байхгүй байгаа нь төрийн албанд зарим нэг чадваргүй, ёс зүйгүй хүмүүс байгаагийн л илрэл байдаг. Гэтэл төрийн албанд насаараа бүх чадлаараа, бүх сэтгэлээ өгөөд зүтгэж байгаа олон мянган хүмүүс байж байгаа. Энэ хүмүүст ирдэг хэлж болдоггүй нэг ийм дарамт байна. Энийг энэ Төрийн албан хаагчийн ёс, зөв хууль дээр бүгдээрээ яаж сайжруулж оруулах вэ? Жишээлбэл удирдлага нь удирдлага нь албан хаагчдаа удирдлагын зүгээс албан хаагчдаа дарамталдаг байдал. Энэ нь батлагддаггүй. Гэхдээ энэ нөхцөл байдал байж л байна. Хууль бус шийдвэр гаргахыг тулгадаг. Энэ асуудал өнөөдөр байж л байна. Энийг яг хэн хянах нь өнөөдрийн бидний энэ өргөн барьсан хууль дээр бас тийм тодорхой биш байгаа. Удирдлагадаа байгаа албан хаагчдаа дарамталдаг, тэднийг хууль бус шийдвэр гаргахад нь нөлөөлдөг тулгадаг. Энийг бол албан хаагчид бол ерөөсөө айгаад хэлж чаддаггүй. Ийм албан хаагчид бас өнөөдөр Монголын төрд бол зөндөө байгаа. Энийг одоо хэн хянах вэ?

Ёс зүйн хороо, ёс зүйн зөвлөлийн эрх үүрэг ажлыг улам сайжруулмаар байна, бэлгэдлийн төдий баймааргүй байна. Ёс зүйн зөвлөл нэлээн өндөр хариуцлагатай ажиллаад ирэх юм бол саяын Бейсен гишүүний хэлээд байгаа улс төрөөс ангид байх улс төржихгүй байх, яг Төрийн албаныхаа хуульд захирагдах гэдэг ажил бол тодорхой хэмжээгээр цэгцрээд бас ирэх юм гэдэг зүйлийг хэлмээр байна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа санал. Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Ер нь бол шаардлагаасаа хоцорч ирж байгаа ч гэсэн маш чухал хууль өнөөдөр манай нөхдүүд санаачилж орж ирж байгаа юм байна. Энэ бол зүйтэй. Энийг дэмжиж байна, хэлэлцээд явах нь зүйтэй гэсэн саналыг хэлэх гэж байгаа юм. Ер нь бид хөгжил гэж яриад байдаг. Хөгжил гэдэг бол хүний хөгжил шүү дээ. Та нар судлаад үзээрэй. Хөгжилтэй орнууд Европын орнууд, Америк, Австрали, Шинэ Зеланд, Япон гээд энэ хөгжилтэй орнуудыг харахад ерөөсөө хүний хөгжил л байгаа юм л даа. Төрийн алба нь ёс зүйтэй, тэнд өндөр чадвартай мэдлэгтэй хүмүүс орж ажилладаг ийм л дүр зураг харагдаж байгаа шүү дээ. Өөр юм ерөөсөө биш. Бид чинь бол газрын баялгаа гадагшаа гаргаад л их баяжчихна л гээд байгаа юм. Хүний хөгжил, хүний ёс зүйн асуудлыг ярихгүйгээр хөгжил гэдэг юм бол байж болохгүй гэж. Япончуудын нэг хэлдэг үг байдаг, ёс зүйтэй хүнд албан тушаал өг гээд. Энэ бол их айхтар мундаг үг шүү дээ.

Ёс зүй гэдгийн цаад талд бол маш их олон асуудал байгаа шүү дээ. Харамсалтай нь сүүлийн үед төрийн албанд манайд бол ёс зүй гэдэг юм бол байхгүй болчихсон. Би

Гаалийн ерөнхий газрын дарга байхдаа Японы гааль дээр очиж туршлага судалж байсан юм. Тэнд бол гаалийн ажилтнууд, үйлчилгээний стандарт гээд, эмэгтэй хүний юбканы хэмжээ өвдгөөс нь доошоо гурван хуруу байна, үсээ хойд талдаа яг ингэж бооно, элдэв бусын шил зүүхгүй, нүүр бол ил байна гээд ингээд бүр заачихсан байдаг юм байна лээ. Тэгээд бид нар бол энийг ирээд бас хэрэгжүүлж л байсан л даа. Одоо чухам яаж хэрэгжиж байдаг юм мэдэхгүй. Төрийн ордноосоо ч гэсэн бид нар эхэлмээр байгаа юм л даа. Энд бол ямар хувцастай байгаа ёстой юм, яах вэ, зүгээр сая жинстэй гаднын хүмүүс орж болохоор хуульчлаад л ингээд л явж л байна. Энд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн хувцаслалтаас өгсүүлээд мэддэг чадвар нь ямар байх ёстой юм. Төрийн албанд орох сонирхолтой хүмүүс сүүлийн үед их болсон. Тэр стандартыг нь тогтоогоод өгчих ёстой л доо. Тийм туршлагатай шалгууртай, 3-аас доошгүй жил ажилласан ч гэдэг юм уу, хэлний мэдлэгтэй ч гэдэг юм уу, тийм, тийм шаардлагуудыг гээд. Тэгээд стандартаа бариад л ингээд тэр сонгон шалгаруулалтаа хийхэд бол энд ямар нэгэн маргаан байхгүй шүү дээ.

Тэгээд сая яригдаж байгаа энэ ялсан нам нь гарч ирээд баахан улсууд төрд томилдог, нөгөөдүүл нь чадвар муутай. Манай энэ хөгжлийн мухардлын нэг гол асуудал бол энэ төрийн албандаа байгаа шүү дээ. Ёс зүй байхгүй ийм л юм байгаа юм л даа. Тэгээд ийм, ийм зүйлүүдийг бүгдийг нь сайн судалж хэлэлцүүлгийн явцад бол анхаарах ёстой. Тэр бүгдийг мэддэг чаддаг хүн гэж ерөөсөө байхгүй. Тийм учраас төрийн албан хаагч бол ёс зүйтэй байхаас гадна энэ ажил дээрээ өсөж мэргэжих энэ боломжийг нь олгох ёстой. Энэ гэрээ хийх дүрэм гэж байгаа юм л даа. Энэ албан тушаал ахих журмыг одоо их тодорхой болгож авах ёстой. Ийм ийм шаардлагуудыг хангах юм бол албан тушаал ахина гээд, тэгэх юм бол ямар нэгэн маргаан байхгүй, хардлага байхгүй болно. Ёс зүйн алдаа гаргасан бол тэр хүн өөрөө огцордог энэ юмыг нь маш тодорхой болгож өг. Ийм шаардлага байна гээд.

Хоёр, гурван асуулт байна. Ёс зүйн хороо гээд байгуулах юм байна л даа. Энэ Төрийн албаныхаа зөвлөлтэй хэр зэрэг нийцэж байгаа юм бол доо? Төрийн албаны зөвлөлийн дарга нь Ёс зүйн хорооны гишүүн байна гэж байгаа юм. Тэгээд Их Хурлаас тэр Төрийн албаны зөвлөл нь Шүүхийн ерөнхий зөвлөл энэ тэр гэдэг шиг Ёс зүйн хороо гэж байгуулах юм байна л даа.

Б.Бат-Эрдэнэ: Баттөмөр гишүүнд 1 минут нэмээд өгөөрэй.

Б.Баттөмөр: Ёс зүйн хороо гэж байх юм байна. Тэгээд 8 гишүүнтэй байх юм уу? Төрийн албаны дарга нь Ёс зүйн хорооны гишүүн. Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулна гээд Ёс зүйн хороо нь Төрийн албаны зөвлөлийн дарга нь хамрагдаад явахаар энэ хэр зэрэг оновчтой юм бол оо? Нөгөө ажил албыг давхардуулж хийхгүй давхардуулж цалин хөлс авахгүй, гээд эдгээртэйгээ хэр зэрэг нийцэж байгаа юм бол доо. Тэгээд Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулах мөртөө Их Хурал зарим бичиг баримтуудыг нь батална гэсэн ийм заалт явж байгаа. Энэ нь хэр зэрэг нийцтэй юм бол доо гэсэн ийм юм байгаа.

Хоёр дахь асуудал төрийн албаны бусад орнуудын туршлагаас яаж судлав, ямар ямар улсуудын туршлагыг судлав? Ямар авмаар юмнууд байна, манай орны нөхцөлд тохирсон ийм юмнууд юу байгаа юм? Энийг яаж энэ хуульдаа тусгасан бэ гэсэн ийм асуултуудад хариулт.

Б.Бат-Эрдэнэ: Мөнбат гишүүний микрофоныг нээж өгөөрэй. Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Ж.Мөнхбат: Баттөмөр гишүүн маань энэ уялдаа холбооны хэр оновчтой зохицуулалт байгаа вэ гэдэг талаар бас асууж байна, тийм ээ? Энэ маш зөв асуулт байгаа. Бид нар анх энэ хуулийн төслийг хийхдээ энэ Ёс зүйн хороог бол ер нь Төрийн албаны зөвлөлтэй дүйцэхүйц байдлаар бие даасан байдалтайгаар хийе гэж ингэж хуулийн төсөл дээр боловсруулсан. Тэгээд яг өргөн барихын үед бас зөвлөлдөж байгаад Төрийн албаны зөвлөл гээд нэг байгууллага байна, дахиад улс үндэсний хэмжээний Ёс зүйн хороо гээд бас нэг байгууллага. Ингээд энэ хоёр нь хоорондоо хэр уялдах вэ, хэр зөрчилдөх вэ гэдэг асуудал яригдаж байгаад ер нь Төрийн албаны зөвлөлийнхөө дэргэд Ёс зүйн хороотой байя, хоёр толгойтой, гурван толгойтой биш нэг толгойтой байя. Гэхдээ энэ бүхнээ ингээд Төрийн албаны зөвлөл, зөвлөл хажуудаа том Ёс зүйн хороотой, Ёс зүйн хороо нь улсын хэмжээнд байгаа энэ ёс зүйн зөвлөлүүдээ нэгдсэн удирдлагаар хангадаг ийм байя гээд. Тэгээд таны саяын тэр ярьж байгаа Төрийн албаны зөвлөлийн дарга Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд орно гэдэг энэ дээрээ бид нар нөгөө жоохон техникийн алдаа гараад засвараа хийгээгүй, өргөн барьсан байна лээ. Тэгэхээр энэ бол ажлын хэсэг байгуулагдаад явахаар энэ зүйлүүдээ, уялдаа холбоо, оновчтой зохицуулалт энэ бүх зүйлүүдээ зохицуулчих юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол ер нь одоо бол Төрийн албаны зөвлөл Улсын Их Хурал, Төрийн байгуулалтын байнгын хорооны үндсэн чиг үүргийн хүрээнд харьяалагдаж явж байгаа. Тэгэхээр 2020 оны Улсын Их Хурлаараа байгуулагдсан парламент бол энэ ёс зүйн асуудлыг чухалчилж Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороотой болоод ингээд ажиллаж байгаа. Энэ хүрээнд бас төрийн албаны энэ ёс зүйн асуудлыг бол бас зөвхөн төрийн алба, Төрийн байгуулалтын байнгын хороо биш Ёс зүйн байнгын хороо бас хариуцах, зөвхөн Ёс зүйн хороон дээрээ журам батлаад ингээд яваад байвал нэг тухайн байгууллагын л юм уу, нэг тийм хэмжээний юм болох болов уу гэж бодож байгаа бид нар. Тийм учраас Улсын Их Хурлаас энэ журам дүрмийг нь баталж өгдөг, энд нь бас тодорхой хэмжээний хяналт юмыг нь тавьдаг ийм байвал бас хариуцлагын хувьд, хяналтын хувьд ч гэсэн өндөр түвшинд байх юм болов уу.

Улсын Их Хурал гэдэг бол өөрөө дөрвөн жилээр шинэчлэгдэж байгаа шүү дээ. Ард түмний төлөөллийн байгууллага учраас ийм байх нь зөв болов уу гэсэн ийм зохицуулалтыг хийсэн. Тэгэхээр тэр таны ярьж байгаа юм, та бол маш зүйтэй бол сайн олж харсан байна. Тэгэхээр энэ зүйлийг бол бид нар ажлын хэсэг дээрээ зохицуулаад явъя гэсэн ийм зүйлтэй байгаа шүү.

Ер нь зүгээр дэлхий дээр энэ ёс зүйгээрээ кодлогдсон хэдхэн улс байгаа. Ёс зүйн хуультай, ёс зүйн кодтой. Жишээлбэл бид нар дэлхий нийт дээр ёс зүйн жишиг жишээ улсыг бол Японоор л бид нар бас ярих дуртай шүү дээ. Сая та ч гэсэн бас сая дурдаж байх шиг байна. Эдгээр улс бол бүгдээрээ ёс зүйн код болон Ёс зүйн хуультай, бие даасан. Энэ хуулийнхаа хүрээнд энэ асуудал нь төрийн албаных нь ёс зүй, сахилга хариуцлагынх нь асуудал зохицуулагдаж явж байгаа юм. Тэр улс төржилт энэ тэр ч гэдэг юм уу, жишээлбэл, төрийн албан хаагч ажилдаа хайнга, алдсан бусад асуудал нь бол Төрийн албаны хуулиараа зохицуулагдана. Тэр хүний ёс зүйн алдаа хариуцлага гаргасан, сахилгын алдаа, хариуцлага гаргасан бол энэ хуулиар зохицуулагдаж явах ийм л юмтай.

Ер нь тэгээд дэлхий дээр тийм олон ч улс байдаггүй юм байна лээ, ёс зүйн кодтой хоёр, гуравхан улс байх шиг байна, хуультай бас хоёрын зэрэг улс байгаа. Тэгэхээр ийм ёс зүйг кодлоод хуульчлаад ирсэн улс орнуудын хувьд бол хамгийн сайн зүйл нь юу вэ гэхээр бол төрийн.

Б.Бат-Эрдэнэ: Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Энэ их чухал хуулийн төсөл л дөө. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Төрийн албан хаагчдын ёс зүй гэдэг бол ер нь их чухал асуудал. Улс төрийн нэр хүнд бол тэр төрийн гаргасан шийдвэр, бодлогыг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч нараасаа бол шууд шалтгаална. Тийм учраас энийг төрийн алба бас нарыг бүх шатандаа ёс зүйтэй болгоно гэсэн энэ хуулийн төсөл бол маш чухал. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ер нь төрийн албан хаагч бол чадварлаг, мэргэшсэн, тогтвортой ажиллавал төр хүчтэй байна гэж. Манайх бол төрийн албан хаагчдыг хоёр ангилж байгаа л даа. Төрийн мэргэшсэн алба хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагч гэж. Төр бол иргэддээ үйлчлэх ёстой, соёлтой үйлчлэх ёстой.

Өнөөдөр яг амьдрал дээр бол бид иргэдийн үйлчлүүлэх үйлчилгээний асуудал дээр бол доголдол маш их байгаа. Тэгэхээр саяын ёс зүйн зөвлөл бол албан байгууллага болгон дээр одоо байгаа. төрийн үйлчилгээний байгууллага болгон дээр байгаа. Төрийн үйлчилгээний доголдол гаргасан хүмүүсийг бол бас тэр зөвлөлөөрөө одоо ч гэсэн хэлэлцэж байгаа. Тэгэхээр энэ хууль маань тэр төрийн захиргааны албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагч нарт бол нийтлэг үйлчилгээ гэсэн ойлголттой байх юм байна. Ер нь төрийн үйлчилгээ дээр бол гарсан доголдлыг яг өнөөдрийн байдлаар тийм судалгаа байгаа болов уу? Ер нь үйлчилгээ дээр бол бид нар их алдаж байгаа шүү дээ. Энэ асуудал дээр бид нар бас их анхаарах хэрэгтэй. Яг энэ шатан дээр ямар өөрчлөлт гараад, энэ хууль батлагдсанаар ямар дэвшил гарах юм бэ?

Хоёр дахь нь бол сая улсын хэмжээнд бол ёс зүйн хороо байгуулагдана гэж. Баттөмөр гишүүн бас асуусан. Энэ ёс зүйн хороо нь шинээр орон тоо нь нэмэгдэх үү, одоо байгаа дотроо Төрийн албаны зөвлөл дотроо бүтэц болоод явах юм уу? Ер нь цаашдаа энэ бодлого батлагдвал энэ хуулийн төслөө ямар шатанд, ямар механизмаар яаж хэрэгжүүлээд хэрэгжилтийн үр дүнг яаж тооцох юм бэ гэсэн асуулт байна. Баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Асуултад хариулъя.

Ж.Мөнхбат: Баделхан гишүүний төр бол иргэддээ үйлчлэх ёстой, соёлтой, хариуцлагатай үйлс үйлчлэх ёстой. Түрүүн Бейсен гишүүн яриад байна лээ, ялгаварлалгүй үйлчлэх ёстой гээд. Энэ бол энэ төрийн үйлчилгээний хамгийн чухал зүйл л дээ. 1996 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас төрийн албан тушаалтны олон улсын ёс зүйн дүрмийг баталж гаргасан. Тэгээд энэ ёс зүйн дүрэм дээр бол ер нь нэлээн тодорхой нарийвчилж заасан юм байна лээ. Тэр нь юу вэ гэхээр нийтийн албан тушаалтны ажил үүргийг гүйцэтгэхдээ дагаж мөрдөх ерөнхий зарчмууд буюу нийтлэг үүргийг нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах, албан үүргээ үнэнч шударга, хууль дүрмийг баримталж, үр ашигтай, үр нөлөөтэй гүйцэтгэх нийтийн хөрөнгийг зүй зохистой ашиглах, аливаа хүнийг ялгаварлан гадуурхахгүй, шударга харьцаж, өөрт олгогдсон эрх мэдлийг зүй бусаар ашиглахгүй байхыг НҮБ-ын Ерөнхий ассамблей 1996 онд бүр дүрэмчилж ингэж баталж өгсөн.

Энэнд тулгуурлаж жишээлбэл энэ ёс зүйн код, ёс зүйн дүрэм, ёс зүйн хуулийг хийсэн улсуудын ер нь ёс зүй, төрийн үйлчилгээ, хөгжлийн асуудал ч гэсэн өндөр түвшинд байгаа юм. Жишээлбэл одоо Япон байна, Сингапур байна, БНСУ, Австрали гээд ийм жишээнүүдийг бол бид нар бас ярьж болно. Тэгэхээр манайд бас нэг жоохон дутмаг байгаа зүйл нь бол төрийн алба бол иргэддээ үйлчилдэг ийм алба байх ёстой гэдгийг мартаад, дарга алба байх ёстой гэдэг захиран тушаах, ийм байр суурин дээр хандах гээд байдаг ийм сөрөг талтай. Тэгэхээр энийг бол бид нар бас энэ Төрийн албан хаагч ёс зүйн сахилгын тухай хуулийн төсөлдөө бас нэлээн сайн хийж өгөх ёстой. Ер нь бол энэ ялгаварлан гадуурхахтай холбоотой ч байдаг юм уу, ухамсар, үүрэг, ёс суртахуунаа умартсантай холбоотой ч юм уу, энэ зохицуулалтууд бол орж ирж байгаа.

Дээрээс нь Төрийн албаны зөвлөл дээр шинэ бүтэц гарах юм уу гэж байна. Ёс зүйн хороо бол ёс зүйн зөвлөл бол өнөөдөр төрийн байгууллагууд дээр байгаа. Гэхдээ хангалттай сайн ажиллаж байгаа гэж хэлж чадахгүй. Энийг та бүхэн ч мэдэж байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар бол ёс зүйн хороотой болно. Ёс зүйн хороо Төрийн албаны зөвлөлийн дэргэд ажиллах юм. Тэгэхээр мэдээж үндэсний хэмжээний энэ ёс зүй, сахилгын асуудлыг зохицуулах ийм хороод болж байгаа юм чинь тодорхой хэмжээний бүтэц бүрэлдэхүүн бий болох л байх л даа. Тэгэхдээ энийг нэг их айхтар нүсэр гэдэг юм уу, төсөв, эдийн засагт нэг хүндрэл учраад байхгүйгээр шийдэх бол боломж бололцоо бол байгаа юм байна лээ. Энэ дээр бол бид нар бас ажил судалж үзсэн.

Хамгийн гол нь яг бодитойгоор тэр улсын хэмжээнд байгаа төрийн байгууллагуудынхаа, ёс зүйн зөвлөлөө удирдах хэрэгтэй, удирдлагаар хангах хэрэгтэй, энэ хуулийн сахиулах хангуулах зүйл заалтыг амьдрал дээр хэрэгжүүлэх энэ л ажлыг бид нар хийх ёстой. Тэгэхээр бид нар нэг хууль ба баталчхаад нэг ёс төдий нэг ингээд байгууллагууд байгуулаад ч юм уу үлддэг, зарим хууль дээр тийм юм бий шүү дээ. Энэ бол тийм биш асуудал байгаа юм. Яагаад вэ гэхээр өнөөдөр бол төрийн нийтийн алба, ер нь улс төрийн албан тушаал, өндөр албан тушаал дээр хамгийн том тавигдаж байгаа юм бол ёс зүйн энэ сахилгын л асуудал байгаа шүү дээ. Тийм учраас хариуцлагатай улс болъё, сахилгатай улс болъё, ёс зүйтэй улс болъё л гэж энэ хуулиар орж ирж байна.

Б.Бат-Эрдэнэ: Би төсөл санаачлагчийн хувьд нэг зүйл нэмж хэлэхэд бид нарын тараасан материалаар нэлээн ултай суурьтай судалгаануудыг хийсэн юм. Тухайлах юм бол энэ судалгааны хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн үндсэн зарчмыг тунхаглан, гишүүн улсууддаа дотоодын хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэхийг уриалсан олон улсын байгууллагууд сонгосон. Тухайлбал НҮБ-аас, Европын зөвлөлөөс өөрсдийнхөө гишүүн улс орнуудад энэ төрийн албан хаагчийн ёс зүйн үндсэн зарчмыг одоо дотоодынхоо хууль тогтоомжоор тогтоож өгөөч ээ гэсэн энэ уриалгын дагуу энийг судалсан. Улс орнуудын хувьд бол парламентын засаглалтай, хөгжингүй болоод хөгжиж байгаа улс орнуудын сонголт хийж судалгаа хийсэн. Би түрүүн хэлсэн, олон улсын байгууллагаас бол НҮБ, Европын зөвлөл, хөгжингүй парламентын засаглалтай улс орнуудаас Япон, Сингапур, Солонгос, Австрали, Канад, Тайвань, Зүүн болон Төв Европын улс орнуудыг сонгож авч харьцуулсан судалгаа юмнууд хийсэн. Энэндээ бол нийтдээ 334 улс орнуудын олон улсын байгууллага, олон улсын энэ жишиг практик, туршлагыг авч үзсэн байгаа. Ийм байгаа юм тодруулж хэлэхэд. Ёс зүйн хороог Төрийн албаны зөвлөл байгуулах, энэ бол нэгдүгээрт Төрийн хэмнэлтийн хууль бодлого гарсан.

Хоёрдугаарт бол чиг үүргийнхээ хувьд бол Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг Төрийн албаны хуулийн 66.1.1-д бол хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид нийт төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах. Энэ үндсэн үүрэг бол хуулиар Төрийн албаны зөвлөлд олгогдсон байгаа. Тийм учраас энэ хуулиар бол ёс зүйн хороог бол Төрийн албаны зөвлөлд байгуулъя. Нөгөө талаараа бол төрийн эрх барих дээд байгууллага парламентаас дэмжлэг үзүүлэх, Улсын Их Хурлын тухай хуулиар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороог тусгайлан байгуулаад, энэ Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд, хуучин Ёс зүйн дэд хороо байхдаа бол гуравхан тодорхой асуудал буюу зөвхөн Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой л асуудал, хуралдааны ирцийг, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудал хариуцаж байсан бол миний түрүүний танилцуулдгаар улс орны хэмжээний төрийн албаны ёс зүйн, сахилга хариуцлагын бодлогыг хариуцахаар ингэж хуульчилж өгсний дагуу бол ажиллах дүрэм журам, бүх юмнуудыг нь Их Хурал дээр Ёс зүйн байнгын хороогоор хэлэлцэж тогтоож өгье. Яг үндсэн үйл ажиллагаа нь бол Төрийн албаны зөвлөл дээр хуулийн дагуу байж байя гэсэн ийм агуулгатай байгаа юм.

Зарчмынх нь хувьд бол бид их зөв дараалаар явж байгаа. Манай Байнгын хорооны гишүүд манлайлаад Улсын Их Хурал бол манлайлал үзүүлээд Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн дүрмээ бол 2009 онд батлагдсан 10 гаран жил үйлчилсэн энэ ёс зүйн дүрмээ зориг гаргаж манай Их Хурал бол энэ удаа шинэчилсэн найруулгаар баталж, нэлээн тодорхой асуудлуудыг нь өөрсдийнхөө төрийн эрх барих дээд байгууллагад ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүд маань өөрсдөө ажиллах нэг зарчмаа бид тогтоож авсан, нэг ойлголтод хүрсэн. Одоо бид нарын хүлээгдэж байгаа асуудал бол орчин үед тавигдаж байгаа өнөөдөр амьдралд шаардаж байгаа тэр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиа бие даая. Тэндээс нь бол сахилгын тухай асуудлыг нь тусад нь гаргаад зөвхөн ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг нь тодорхой хуульчилж өгье л гэсэн ийм л зүйл байгаа гэдгийг гишүүддээ хэлье.

Ингээд санал хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Нэрсээ өгөөрэй. Баярсайхан гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүнд микрофон өгье.

Б.Бейсен: Энэ Төрийн албаны тухай хууль, тэгээд энэ төрийн албан хаагчийн ёс зүйн байдалтай холбоотой нэг санал хэлье гэж бодож байна. Ялангуяа төрийн үйлчилгээний байгууллагууд байна шүү дээ. Эмнэлэг сургууль, цэцэрлэг. Энэ дээр нь ард түмэнд хүндлэгдсэн ёс зүйтэй, мэдлэг мэргэжил сайтай тийм хүн тавихгүй бол ялангуяа эмнэлгийн байгууллагууд дээр чинь захирагдахгүй, нөгөөдүүл нь бас ёс зүйгүй харьцдаг асуудлууд гарч байгаа юм. Энэ дээр бас анхаарах шаардлагатай байгаа юм. Хоёрдугаар бүлгийн 7.1.2 дээр нэг санал нэмж хэлмээр байх юм. Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх гэдэг дээр аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх гээд нэмэх тийм саналтай байна.

Дараа нь Хоёрдугаар бүлгийн 8.1.1 дээр албан үүргээ гүйцэтгэж байхдаа гээд, согтууруулах ундаа хэрэглэх, байгууллагын дотоод журам болон холбогдох бусад журамд нийцэхгүй байдлаар хувцаслах гэсэн байна. Энэ дээр чинь … гүйцэтгэж гүйцэтгэж байхдаа мансууруулах бодис гээд бас нэммээр байна. Сэтгэцэд нөлөөт эм байна, бас бодисууд байна. энийг бас нэмж, тэгээд албан журамд нийцэхгүй байдлаар хувцаслахыг хориглоно гээд оруулахгүй бол сая хөдөөгүүр явж байхад сургуулийн

захирлууд, зарим албан байгууллагынхан курткатай, ноосон цамцтай сууж байх юм. Бас нэг зангиа, пиджактайгаа сууж байвал ард түмэнд хүндлэгдэнэ шүү дээ. Энэ байдлыг албан ёсоор хориглоод, тийм байдалтай хувцасла гэж яахгүй болохгүй юм шиг байна.

Дараа нь 8.3.1-ийн “а” дээр өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах гээд байна л даа. Энэ дээр ард түмнийхээ гэдгийг нийтийн гэсэд оруулж болох уу? Энийг бас олонхоороо шийдээд нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос гэсэд оруулбал ямар вэ гэсэд санал хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Баттөмөр гишүүн саналаа хэлье. Бейсен гишүүнд баярлалаа.

Б.Баттөмөр: Энэ чухал хууль. Мөнхбат гишүүн, Баярсайхан гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн эд нар оруулж ирж байгаа юм. Цаг үеэ болсон цаг үеэсээ хоцорч байгаа ч гэсэн яг өнөөдөр маш чухал ийм хууль байна. Энийг дэмжиж байгаагаа би дахиж илэрхийлье гэж бодож байгаа юм. Ер нь бол ёс зүй гэдгийн цаад талд бол маш их олон асуудлууд байгаа юм. Бид стандарт гэж хэлдэг шүү дээ. Стандарт гэдэг бол орчуулгаар хэв хэмжээ гэж. Гэхдээ нөгөө утгаараа хэлэх юм бол энэ тоглоомын дүрэм юм л даа. Төр бол тоглоомын дүрмээ л маш тодорхой болгочих ёстой юм байгаа юм. Тэгвэл ерөөсөө энд янз бүрийн маргаан, янз бүрийн асуудал бол гарахгүй. Би бол энд одоо юу гэж хэлэх гэж байна гэхээр түрүүн ч бас цухас дурдаад өнгөрсөн. Мэдлэг гэж юу юм бэ? Энийг тодорхой стандарттай болгож өгөх хэрэгтэй. Мэдэхэ хэлний боловсрол бол байх л байх. Улсад ажилласан жил, туршлага, эрсдэл тооцох чадвар гэсэд энэ юмнууд мэдлэг чадварын стандартад орно.

Дараагийн асуудал бол юу гэхээр үйлчилгээний стандарт. Төрийн албанд бол сүүлийн үеийн нэг моод болчихсон, янз бүрийн уранхай цоорхой хувцас өмсөөд ч юм уу, эсвэл нэг үсээ хусуулчхаад ч юм уу, эсвэл нэг том нүдний шил хийчхээд ч юм уу, хүний урдаас нэг гөлрөөд ч юм уу, урд удаан алхах энэ юм ерөөсөө байдаггүй юм байна лээ. Энийг бүгдийг нь хуульчлаад ингэсэд өгчихсөн байдаг. Төрийн албан хаагч ямар байх ёстой юм тэрийг нь хийгээд өгчих.

Дараагийн асуудал нь карьер хийх стандарт байгаа. Манай дээр дарга ирээд тийм хүнийг томилчихлоо, тэр хүнийг тэгчихлээ, тэр тэрний хүн гэсэд л. Үгүй ээ, би гурван жил ажиллаад ийм амжилт гаргах юм бол мэргэжилтэн байж байгаад ахлах мэргэжилтэн болно, таван жил ажиллаад би ийм амжилт гаргах юм бол хэлтсийн дарга болно, Газрын дарга болно, стандарт нь тодорхой байх ёстой. Тэгээгүйгээс болоод бас л янз бүрийн хардлага сэрдлэг энэ төрийн албанд байдаг. Дараагийн стандарт бол хариуцлага хүлээх стандарт. Ажил дээрээ архи уусан бол шууд маргааш нь халагдах өрөгдлөө өөрөө гаргадаг, хүнтэй ёс зүйгүй харьцсан бол тэр нь хариуцлагаа хүлээдэг, мэдлэг чадвар дутагдсан бол тэрийгээ хүлээдэг. Энэ ёс зүй гэдэг юмны цаад талд ийм их олон юмнууд байгаа юм л даа. Тэгээд би бас та нарын энэ оруулж ирж байгаа саналыг дэмжиж юм. Тэгээд би бас ажлын хэсгийнх нь бүрэлдэхүүнд орж ажиллая.

Өнөөдөр харамсалтай нь бол сая Мөнхбат гишүүн бас тодорхой хэллээ л дээ. Төрийн алба гэдэг бол ард түмэндээ үйлчилдэг алга, улс эх орондоо өөрчилдөг алба

гэж. Энийг ухаардаггүй хүмүүс өнөөдөр маш их олон байгаа шүү дээ. Төрийн албанд ер нь нэг цалин авъя, амьдрал ахуйгаа дээшлүүлье гэдэг ийм бодолтой ордог хүмүүс ний нуугүй хэлэхдээ аягүй их олон болчихсон. Энэ бол одоо юу вэ гэхээр бид тоглоомын дүрмээ тодорхой болгож өгөөгүйгээс бас буруутай. Тэр хүмүүсийг буруутгахаас илүү.

Энэ ёс зүй гэдэг юм дотор хэмнэлтийн тухай ч орно. Өнөөдөр нэг байгууллага гэж байгаа юм. Тэгээд л 1000 хүнтэй, 1800 хүнтэй, 1500 хүнтэй том том агентлагууд байна. Сая дэд дарга энэ тэрийг нь цомхотгоод, машин унааг нь аваад. Энэ бол эхлэл. Цаашаа энэ үргэлжлэх ёстой. Нэг агентлаг гэхэд бол өнөөдөр шинжлэх ухаан технологи хөгжсөн, мэдээллийн технологи хөгжсөн үед цахим болсон энэ үед ийм их нүсэр орон тоотой ингээд байгаад байх уу, үгүй юу. Энэ болгон бүгд стандартууд байх ёстой юм байгаа юм. Энэ ч гэсэн одоо ингээд ороод ингээд явна гэж байгаа юм. Ер нь төр тоглоомын дүрмээ л их тодорхой болгочих юм болбол бүх юм аяндаа л цэгцрээд л явчихна. Ажилд орохдоо бол стандартаа мэддэг, тэрэн дээрээ хүлээн зөвшөөрөөд гарын үсэг зурдаг, албан тушаал ахихдаа тэрийгээ бариад ингээд явчихдаг, хариуцлага хүлээх болохоороо янз бүрийн шүүх, ийм, тийм гээд байх юм байхгүй, элдэв бусын төрийн албанд чирэгдэл үүсгэхгүйгээр зайгаа тавьж өгөөд явчхаж чаддаг гээд ийм, ийм юмнууд байгаа юм. Тэгээд, зүйтэй хэлэлцье. Ажлын хэсэг байгуулъя, явц дунд нь сайжруулъя, бүгдээрээ. Энэ бол Монголын төрд бол жишиг хууль болох ёстой. Маш чухал хууль орж ирж байна. Ингээд дэмжиж байна, энийг.

Б.Бат-Эрдэнэ: Баттөмөр гишүүнд их баярлалаа. Манай Байнгын хорооны гишүүд бол ер нь бүгдээрээ төрийн албаны туршлагатай, хариуцлагатай төр улсдаа хариуцлагатай ажил алба хийж, ард иргэд, сонгогчдынхоо саналыг авч олон удаа парламентад ажилласан ийм туршлагатай гишүүд байгаа л даа. Баттөмөр гишүүнд их баярлалаа. Монголын хамгийн чухал, гааль, татвар бусад томоохон байгууллагуудыг удирдаж, хөл дээр нь босгож, үлгэр жишээ, зарчим стандартыг тогтоож ажиллаж байсан таны туршлага маш чухал учраас энэ хэлэлцэх эсэхийг нь Их Хурал шийдчих юм бол энэ ажлын хэсэг дээр орж үнэтэй санал санаачилгуудыг гаргаж, яг таны хэлдгээр өнөөдөр ус, агаар мэт дутагдаж байгаа төрийн албанд. Төрийн алба гэдэг бол Монголын нийгмийн нүүр царай, Монголын нийгмийг чирч явах чиглүүлэгч луужин байдаг учраас энэ төрийн албаны стандарт энэ ёс зүйн хэв хэмжээг тогтоох, энэ ёс зүйн тухай хууль дээр идэвх санаачилгатай, өөрийнхөө мэдлэг, хуримтлуулсан туршлага, жишгүүдийг суулгаж өгч ингэж ажиллахыг танд хүсэж байна. Баярлалаа. Баярсайхан гишүүн саналаа хэлье.

Б.Баярсайхан: Энэ хууль бол нийгмийн захиалга юм. Сүүлийн гучин жил хүний хөгжлийн бодлого алдагдсан, сайн зан чанартай сайн хүн бэлтгэх гэр бүлийн хүмүүжил, ёс зүй, ёс жудаг энэ зүйл одоо алдагдсан учраас өнөөдөр нийгэм ийм бухимдалтай, төрийн түшээгээсээ авхуулаад төрийн албан хаагчдыг ёс зүйтэй байхыг шаардсан хашхирсан ийм цаг хугацаа байгаа.

Улсын Их Хурлын гишүүд нь өнөөдөр ёс зүйн хуулиа батлаад тангараг өргөөд ингээд явж байгаа нь засаг барьж байгаа Монгол Ардын Намын бас нийгмийн захиалгыг биелүүлж байгаа энэ нийгмийг илүү ёс зүйтэй байхад өөрсдөөсөө эхлэх ёстой гэж ухамсарлаж байгаа ийм ажил. Дараагийн ажил болбол энэ төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх. Ингэж чадах юм бол нийгэм төрдөө итгэж нийгэм илаарьшиж, Монголын нийгэм илүү ёс зүйтэй болох энэ суурь

тавигдана гэж үзэж байгаа юм. Тийм учраас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль бол маш чухал хууль. Энэ дээр хоёр бас санал байна.

Сая Мөнхбат дарга олон улсын туршлагуудыг нэлээн их ярьж байна. Яг энэ олон улсад бол ерөөсөө ажилд аваад ажилласны дараа биш ажилд орохоос нь өмнө тэр хүн ямар нэр хүндтэй сургууль төгссөнөөс нь үл шалтгаалан ерөөсөө тухайн хүний төлөвшил хандлага, хүмүүжил зан, чанарын төлөвшил нь ямар байна гэдгийг л илүү их харж, анх төрд оруулахаасаа өмнө тэр хүмүүсээ сонгон шалгаруулахдаа энэ төлөвшил зүй гэдэг зүйл дээр бол анхаардаг. Ингэж бид нар цензуртэй хандаж чадах юм бол заавал буруу хүмүүжсэн хүнийг төрийн албанд орж буруу зүйл хийснийх нь дараа хариуцлага тооцох биш, анх төрд авахдаа л маш сайн сонгон шалгаруулалт хийх ёстой гэдэг нэг ийм ажлыг Монголын төрийн албанд ороход нь бас хэрэгжүүлэх шаардлагатай юм болов уу гэж хардаг.

Хоёрдугаарт, 15 дугаар зүйл дээр төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх энэ зүйл заалт байгаа. Өнөөдрийн жишгээр бол яаж яваад байна вэ гэхээр ёс зүйн хариуцлага гаргасан, ямар нэгэн байдлаар авлигын асуудалд холбогдсон төрд санхүүгийн хохирол учруулсан ийм хүмүүс ерөөсөө ажлаас халагдаад л өөрийгөө ажлаас хариуцлага хүлээчихсэн гэж ойлгоод байгаа байхгүй юу. Ажлаа өгчихсөн бол хариуцлага хүлээчихсэн гэж ойлгоод байгаа юм. Тэгэхээр 15 дугаар зүйл дээр төрийн албан хаагчаар ажиллаж байхдаа төрд ямар нэгэн байдлаар санхүүгийн хохирол учруулсан, авлига хээл хахууль авсан бол, ажлаа хүлээлгэж өгснөөс нь хойш ч гэсэн хугацаагүйгээр энэ хүнтэй хариуцлагыг нь тооцож улсыг хохиролгүй болгох тэр ажлыг нь хийлгэх ийм хариуцлага хүлээх ёстой гэж үзэж байна.

Өнөөдөр Монголын төрд хуурамч дипломтой хүмүүс бол асар олон байгаа. Ийм хуурамч дипломоор төрд шургалж орж ажил хийж байгаа хүмүүсээс бид нар ямар чадвар нэхэх юм, ямар ёс зүй асуух юм, тийм биз? Тийм учраас төрд орохдоо л ингээд хуурч орж байгаа хүмүүсээс бид нар бол юу ч хүлээх шаардлагагүй ээ. Тийм учраас энэ зүйлүүдийг бас энэ хуульд бас нэлээн тодоор цаашдаа тусгаад явах нь зүйтэй юм байна гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Их баярлалаа. Хуулийн төсөл санаачлагч Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат гишүүнд микрофон өгье.

Ж.Мөнхбат: Байнгын хороодын гишүүд маань, ер нь ихэнх зүйлүүдийг ярьчихлаа даа. Манай Баттөмөр гишүүн түрүүн Японы жишгээ бас жишээ болгож ярьж байна лээ. Өнөөдөр Монгол Улсад үгүйлэгдэж дутагдаж байгаа энэ чухал хууль байгаа. Би тэгээд бас энэ хуулийн төслийг бичиж боловсруулахад туслалцаа үзүүлсэн Улсын Их Хурлын Тамгын газрын хамт олон, манай зөвлөхүүд, одоо энэ арын эгнээнд сууж байна, Судалгааны хүрээлэнгийн хамт олон бүгдэд нь бас талархал илэрхийлж байна. Удирдлагын академийн хамт олон. Тэгэхээр дэлхий нийтийн сайн чанар жишгээс бид нар суралцаж авах ёстой юм байна лээ. Дэлхий дээр Япон, Тайвань хоёр бие даасан хуультай. Солонгос бол Төрийн албаны хуулийг Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмтэйгээ 2003 оноос хойш хослуулан хэрэглэж байгаа. Канад одоо ёс зүйн кодтой байна.

Ёс зүйн дүрмээр зохицуулж байгаа улсууд гэх юм бол Канадыг оруулж болох юм, Австралийг, Сингапурыг, манай өмнөд хөрш Хятад улс хүртэл бас энэ төрийн албыг

бол ёс зүйн дүрмээр зохицуулалт хийгээд ингээд явж байгаа. Тэгэхээр энд бол сахилга хариуцлага байна, төрийн үйлчилгээ хүнд сурталгүй байна, авлигаас ангид байна. Маш олон зүйлийн давуу талууд байгаа. Тэгэхээр энэ бүхнийг бүгдээрээ энэ хууль дээрээ ажлын хэсэг гаргаж сайхан хариуцлагатай бүгдээрээ ажиллаж. Мэдээж ажлын хэсэгт хууль санаачилсан гишүүд бол орж болохгүй ийм зохицуулалттай. Тэгэхээр манай Байнгын хороодын гишүүд маань оролцож идэвхтэй сайн ажиллаасай гэж бас хүсэж байгаа.

Энэ хуульд бас нэг зүйл байгаа. Одоо энэ хууль батлагдаад ингээд хэрэгжээд эхлэхтэй зэрэгцээд ёс зүй, сахилга хариуцлага алдсан гэдэг үндэслэлээр их олон хүнийг хариуцлага тооцож, ажлаар бас хууль бусаар халах уу, ийм нөхцөл байдал бүрдэх вий. Тэгэхээр энийг хэн нэгэн дарга албан тушаалтан дур зоргоороо авирладаг байдлыг бол нэлээн сайн хааж хийх гэж бид нар ажилласан. Энийг улам сайн боловсронгуй болгох ийм шаардлага энэ дээр дахиж ажиллах юм бол ажлын хэсэг дээр анхаарах зүйл бол байгаа шүү гэдгийг бас хэлье гэж бодож байна. Баярлалаа та бүхэндээ.

Б.Бат-Эрдэнэ: Их баярлалаа. Би нэг, хоёр зүйл хэлье. Энэ өмнө нь бол албан байгууллагуудын дэргэд байгуулагдаж байгаа 25-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй албан байгууллага болон ёс зүйн зөвлөлүүдийг байгуулж ажиллаж байсан. Тэгээд энэ ёс зүйн хороо зөвлөлүүдийн удирдлагыг бол дээрээс нь шууд томилж хийсэн ийм муу жишиг практик байсан. Энийг бол халсан. Хамт олны хурлаас ёс зүйн зөвлөлд ямар хүмүүсээ оруулах юм бэ, тэгээд саналаараа, ил тодоор ардчиллын зарчмаар сонгож оруулдаг. Оруулсныхаа дараа байгуулагдсан ёс зүйн зөвлөл нь хуралдаад тэр удирдах өөрийнхөө тэр ёс зүйн зөвлөлийг ахлах хүнээ сонгодог ийм зарчмаар орж байгаа. Тэгэхээр энэ хуульд бол энийгээ баталгаажуулаад ингээд аваад явна. Нөгөө нэг юм нь бол дандаа туршлагатай парламентч, төрийн албаны туршлагатай хүмүүс байж байгаа учраас манай Байнгын хорооны дарга нар, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга ч анхаарах байх. Төрийн эрх мэдлийг авдаг онцгой эрхтэй субъект Улс төрийн намуудын хууль дээр энэ хүний нөөцийн асуудал, боловсон хүчний бодлогын чиглэлийн юм, цаашлах юм бол санхүүжилт, дүрмийн хүрээнд, үзэл баримтлалынхаа хүрээнд ажилладаг улс төрийн намуудын төлөвшилд энэ Улс төрийн намуудын хууль бол их жинтэй хувь нэмэр оруулна. Энэ дээр анхаарлаа тавих байх гэж бодож байгаа.

Гишүүдийнхээ саналтай бол санал нэг байгаа. Энэ хэлэлцүүлгийн явцад улам сайжруулаад ингээд явах бололцоо бүрэн нээгдэж байгаа. Тийм учраас манай Байнгын хороодын гишүүд Улсын Их Хурлын чуулганаар энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь ярилцах үеэр та бүхэн маань тодорхой байр суурь илэрхийлж, ингээд энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь шийдээд д хэлэлцүүлгийн явцад сайжруулах чиглэлээр анхаарал тавьж ингэж өгөөрэй.

Нөгөө талынх нь бол Бейсен гишүүн түрүүн хэлсэн. Нийтийн алба, энэ манай Монголын хууль эрх зүйн тогтолцоонд бас орсон шүү дээ, нийтийн алба. Ер нь төрийн албанд энэ нийтийн албанд тангараг өргөсөн хүнд нийтийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой юман дээр л ёс зүй өндөр байх ёстой, хариуцлагатай байх ёстой, хатуу, өндөр үүрэг хүлээж ажиллах ёстой гэдэг энэ зарчим руу нь тулгахгүй бол манайханд, нийгэмд байдаг юм бол нэг юмыг ингэж нэг тал руугаа татдаг, хувийн ажил амьдралтай нь холбоотой юм руугаа татаад баахан хар будаг түрхдэг, нөгөө нийтийн эрх ашгийг хохироосон том том асуудлыг нь тэр хувийн жижиг юмаар нь саармагжуулж хэн ч

хариуцлага, тооцохгүйгээр ингэж хаядаг. Тэгээд энэ 30 жилийн хулгай худал, энэ чинь гол юм тэнд байна шүү дээ. Тийм учраас энэ нийтийн албанд тангараг өргөсөн хүмүүс бүх шатандаа ямар ёс зүйтэй, ямар сахилгатай, ямар хариуцлагатай, тэр хариуцлагаа түрүүн Баярсайхан гишүүний хэлдгээр ямар ч тохиолдолд бол хэзээ ч хугацаа хамаарахгүйгээр тэрийгээ хүлээдэг ийм зарчим тогтоож ийм соёлыг бий болгож ажиллах бол чухал байгаа юм гэдгийг эцэст нь хэлээд ингээд одоо санал хураалт явуулна.

Гишүүд асуулт асууж дууссан. Сая санал хэлж дууслаа. Байнгын хороо хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулж, гишүүдийн олонхын саналаар санал, дүгнэлтээ гаргаж, нэгдсэн хуралдаанд оруулна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

100 хувийн саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг Баттөмөр гишүүнийг томилъё. Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг асуудлыг хэлэлцэж, хэлэлцүүлгийг хийж дууслаа.